



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/571

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 09/10 дугаар тогтоол, Эрүүл Мэндийн Сайд, аймгийн Засаг дарга нарын 2019 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.2.4, 3.2.2.5 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашины яаралтай үеийн бэлэн байдлыг хангах тоног төхөөрөмж, зайлшгүй шаардлагатай рентген аппарат, техник хэрэгсэл, өрхийн эмнэлгүүдийн эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах, осол гэмтлийн бүсийн сургалт зохион байгуулах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардал нийт 346.114.000 (гурван зуун дөчин зургаан сая нэг зуун арван дөрвөн мянга) төгрөгийг Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, тоног төхөөрөмжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг Даргын Тамгын Газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр), Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101042